



МУИС-ЭЗХ



ӨМИС-МУСХ

**БНХАУ-ын ядуурлаас ангижруулах бодлогын
хэрэгжилт: ӨМӨЗО-ы Хянган аймгийн жишээ**

Судлаач: С.Амартүвшин

МУИС. ЭЗХ

Email: amartuvshin.s@num.edu.mn

Утас: 80020828

Улаанбаатар хот

2019 он

Агуулга

Оршил	2
БНХАУ-д хэрэгжиж буй ядуурлаас ангижруулах бодлогын өнөөгийн байдал	3
ӨМӨЗО-д хэрэгжүүлж буй ядуурлын эсрэг бодлого хөтөлбөрүүдийн тойм.....	9
Хянган аймгийн Хорчин баруун гарын дундад хошуунд хэрэгжүүлж буй ядуурлаас ангижруулах ажлын жишээ.....	13
Дүгнэлт.....	18
Ашигласан материал.....	21

Оршил


2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 70-р чуулганаар Тогтвортой хөгжлийн зорилгыг 17 зорилго 169 зорилтойгоор баталсныг дэлхий нийтээр хэрэгжүүлж байна. Энэхүү ТХЗ-ын нэгдүгээр зорилго нь ядуурлыг устгах явдал бөгөөд энэ ажлын хүрээнд 7 зорилтыг 14 үзүүлэлтээр хэмжиж байхаар тогтсон. ТХЗ-ын нэгдүгээр зорилго нь 2030 он гэхэд дэлхий даяар ядуурлыг устгах явдал бөгөөд нэн тэргүүнд өдрийн орлого нь 1.25 ам.доллараас бага орлоготой гэж тооцогдож буй хүн амыг ядуурлаас ангижруулахаар зорьж байна. Дэлхийн хамгийн олон хүн амтай улс болохынхоо хувьд БНХАУ нь ядууралтай тэмцэх асуудлыг анхаарлын төвдөө авч дөчин жилийн турш ядуурлыг бууруулах арга хэмжээг эрчимтэйгээр хэрэгжүүлж байна. Зарим эх сурвалжийн тооцоогоор БНХАУ нь эдийн засгийн шинэчлэл хийсэн сүүлийн 40 жилийн хугацаанд 730 сая хүнийг ядуурлаас гаргасан нь тухайн хугацаанд дэлхий дахины хэмжээнд ядуурлаас гаргасан хүн амын 70 хувьтай тэнцэнэ. Энэ бол маш том амжилт. Энгийн үгээр хэлбэл нэг минут тутамд 20 хүнийг ядуурлаас гаргаж байна.

Энэхүү өгүүлэл нь үндсэн 4 хэсэгтэй бөгөөд нэгдүгээр хэсэгт БНХАУ-ын ядуурлын өнөөгийн нөхцөл байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн талаар товч авч үзэв. Дараагийн бүлэгт ӨМӨЗО-ы өнөөгийн нөхцөл байдал, ядуурлыг бууруулах, ядуурлаас ангижруулах бодлогын хэрэгжилтийн талаар тоймлон авч үзсэн бол гуравдугаар хэсэгт Хянган аймагт хэрэгжүүлж буй бодлого хөтөлбөрүүдийн онцлогийг тодруулан харуулж, Хорчин баруун гарын дундад хошуунд ядуурлаас ангижруулах бодлого хэрхэн хэрэгжиж байгааг кейс жишээгээр тайлбарлан төгсгөлд нь судлаачийн зүгээс дүгнэлт, санал өгөхийг зорив.

БНХАУ-д хэрэгжиж буй ядуурлаас ангижруулах бодлогын өнөөгийн байдал

БНХАУ нь Азийн бусад орнуудтай адил хүн ам олонтой, орлого багатай, нэг хүнд ногдох нөөц, баялаг хомс боловч эдийн засгийн тогтвортой өндөр өсөлтийг сүүлийн 40-өөд жилийн хугацаанд харуулж байгаа, маш хурдан хугацаанд чинээлэг нийгмийг бүтээн байгуулж буй дэлхийн хамгийн том эдийн засгуудын нэг юм. 1970-аад оны сүүлчээс эхэлсэн эдийн засгийн институцийн шинэтгэлийн үр дүнд ДНБ-ий жилийн дундаж өсөлт нь 10 хувиас дээш гарч үр дүнд нь иргэдийн амьдралын чанар үсрэнгүй өсөж, хүн амын ядуурлыг үлэмжхэн хэмжээгээр бууруулжээ. Тухайлбал, 1981 онд хүн амын 85 хувь нь өдрийн 1.25 ам.доллараас бага орлоготой байсан бол 2008 он гэхэд 13.1 хувь болтол буурсан (ойролцоогоор 700 сая хүнийг ядуурлаас гаргасан) нь маш том амжилт юм.¹ 2017 оны байдлаар БНХАУ-ын хувьд ядуурлын үндэсний түвшнээс доогуур амьжиргаатай хүн амын эзлэх хувь 3.1 байгаа нь бүс нутгийнхаа бусад улс, бие даасан эдийн засгуудтай харьцуулахад маш бага байна (Зураг 1).


Зураг 1. Ядуурлын үндэсний түвшнээс доогуур амьжиргаатай хүн амын эзлэх хувь, 2017 он



Эх сурвалж: ADB - Basic Statistics 2019

БНХАУ-ын дарга Ши Жинпин 2017-2020 оны хооронд хийх гурван хүнд тулааны (preventing financial risks, reducing poverty and tackling pollution) нэг нь ядууралтай тэмцэх компани ажил байх болно гэж тодорхойлж, төрийн үйл ажиллагааг энэ чиглэлд улам илүү хандуулах болсноор 2018 оны эцэс гэхэд ойролцоогоор 16.6 сая буюу нийт хүн амын дөнгөж 1.7 хувь нь үндэсний ядуурлын шугамаас (2300 юань) доогуур орлоготой үлдсэн бөгөөд 2020 он гэхэд бүх улс даяар ядуурлаас бүрэн ангижрахаар төлөвлөн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд төрийн албан хаагчид ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаа бөгөөд 2016 оны байдлаар нийт улсын хэмжээнд 775000 албан хаагч (кадр) орон нутагт ажиллажээ.


Зураг 2. БНХАУ-ын ядуурлын бууралт



¹ Human development report 2009 – “Population living below \$2 a day (%)”

2010 онд хятадын нийт хүн амын 17.3 хувь буюу 230 сая хүн ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай гэж бүртгэгдэж байсан бол 2017 он гэхэд дөнгөж 3.1 хувь буюу 43 сая хүн болж ойролцоогоор 187 сая хүнийг ядуурлаас ангижруулжээ. Ядууралтай тэмцэх эрчимжүүлсэн компанит ажлын үр дүнд 7 жилийн дотор ядуу хүн амын тоог 5.4 дахин багасгаж, ядуу хүн амын эзлэх хувийг 14.1 пунктээр бууруулсан (Зураг 2). 2020 оны зорилтдоо хүрэхийн тулд зөвхөн 2019 онд гэхэд улсын төсвөөс 91 тэрбум юань зарцуулж байгаа бол Хятадын хөгжлийн банкнаас ядуурлын эсрэг төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхээр 400 тэрбум юань төсөвлөжээ. Үүний зэрэгцээ төсвийн хөрөнгийн зарцуулалтыг хянах, авилгатай тэмцэх зорилгоор компанит ажил өрнүүлж, 60000 орчим зөрчил тохиолдлыг шалган 730 сая юаны буруу зарцуулалтыг илрүүлэн, хохирлыг барагдуулсан. Хэдийгээр ядуурлын эсрэг энэ мэт томоохон ахиц дэвшил гарч байгаа боловч орлогын тэгш хуваарилалттай холбоотой асуудлууд анхаарлын төвд байсаар байна. Тухайлбал, 2018 оны байдлаар өдрийн орлого нь 1.9 ам.доллараас бага хүн амын тоо 9.9 сая, 3.2 ам.доллараас бага орлоготой хүн амын тоо 95.5 сая, 5.5 ам.доллараас бага орлоготой хүн амын тоо 373.1 сая байгаа нь ядуурал БНХАУ-д хамгийн чухал асуудлуудын нэг болохыг харуулж байна.²

Зураг 3. Орлого хуваарилалт, хүн амыг таван тэнцүү бүлэгт хуваасан байдлаар




Ерөнхийдөө 1990 оноос эхлэн орлогын хуваарилалт илүү тэгш бус болж, чинээлэг иргэд ядуу иргэдээс илүү хурднаар нөөц баялгийг эзэмших болжээ. Орлогын хуваарилалтын чиг хандлагыг харвал 1990 онд хүн амын хамгийн ядуу 20 хувь нь нийт орлогын 8.3 хувийг эзэмшиж байсан бол энэ үзүүлэлт тасралтгүй буурсаар 2010 гэхэд хамгийн бага түвшиндээ буюу 5.1 хувьд хүрсэн. Улмаар бага зэрэг нэмэгдэж, 2014 он гэхэд 6.4 хувь болжээ. Харин хүн амын хамгийн баян 20 хувь нь 1990 онд нийт баялгийн 40.8 хувийг эзэмшиж байгаад эзлэх хувийн жин нь нэмэгдсээр 2010 он гэхэд 49 хувь болж оргилдоо хүрсэн бөгөөд алгуур буурсаар 2014 он гэхэд 45 хувьд хүрчээ (Зураг 3). Энэ байдал нь орлогын тэгш бус хуваарилалтыг харуулах Жини индексийн тооцооллоор мөн адил харагдаж байна. 1990 онд БНХАУ-ын хувьд баян ядуугийн ялгаа хамгийн бага буюу 32.3 байсан бол уг индекс огцом өссөөр 2010 онд хамгийн их утгаа авч 43.9 болжээ. Улмаар 2015 он гэхэд уг үзүүлэлт 5.1 нэгжээр буурч 38.6 хувьд хүрээд байна (Зураг 4). Ядуурлыг бууруулахыг нэн тэргүүнд авч үзэхийн зэрэгцээ орлогын тэгш бус хуваарилалтыг багасгах нь

² <http://povertydata.worldbank.org/poverty/country/CHN>

тус улсын засгийн газрын чухал зорилтуудын нэг болох тул энэ талаар хэд хэдэн томоохон арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Зураг 4. Жини индекс, Дэлхийн банкны тооцоолол




Эх сурвалж: World Bank - Poverty & Equity Data Portal

2011 онд БНХАУ-ын Төрийн зөвлөлийн шийдвэрээр XII таван жилийн төлөвлөгөөнд орлогын тэгш бус хуваарилалтыг аль болох хурдан багасгах хэрэгтэй гэж тусгасан. Улмаар XIII таван жилийн төлөвлөгөөнд (2016-2020) 2020 он гэхэд ядуурлыг бүр мөсөн устгах зорилт дэвшүүлэх замаар орлого хуваарилалтыг сайжруулахаар төлөвлөсөн. Олон тооны мэргэжилтэн, судлаачид энэхүү зорилт хугацаандаа бүрэн хангагдах боломжтой гэж үзэж байна. Учир нь ядуурлыг бууруулах бодлогод сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд үр дүнтэй хэд хэдэн шинэчлэлийг хийсэн гэж үздэг. БНХАУ ядуурлаас ангижруулах компаниг ажлыг амжилттай хэрэгжүүлж байгаа нь ядуурлыг үүсгэж буй уг үндэстэй нь тэмцэж байгаа явдал юм.³ Тус улсын хувьд ядуурлын шалтгаан нь дараах хэд хэдэн ерөнхий нөхцөл байдалтай холбогддог. Үүнд:

Хотод түшиглэсэн хөгжлийн бодлого. Энэ нь хөдөөгийн иргэдийн ядуу байдлын нэг чухал шалтгаан болохыг зарим судалгаанууд харуулсан. Хүнд аж үйлдвэрийн хөгжлийг илүү дэмжсэн, хотын татаас олгодог төвлөрсөн төлөвлөгөөт систем ба ХАА-н бүтээгдэхүүний байнгын илүүдэл нь хөдөө ба хотын иргэдийн хооронд орлогын ихээхэн зөрүүг үүсгэжээ (Yang 1999).

Зураг 5. Хот хөдөөгийн иргэдийн орлогын ялгаа, 1980-2014



Эх сурвалж: <https://geopoliticalfutures.com>

³ Jain-Chandra et al. (2019) Inequality in China – Trends, Drivers and Policy Remedies, IMF Working paper series

1980–90-ээд оны туршид иргэдийн 73-76 хувь нь хөдөөд амьдарч байхад улсын төсвийн хөрөнгө оруулалтын 10 хүрэхгүй хувь нь ногдож байв (Зураг 5).

Далайн эргийн болон дотоод газрын ялгаатай байдал. Нээлттэй хаалганы бодлого хэрэгжиж эхэлснээр эргийн болон эх газрын дотоодод оршин суугчдын орлогын үндсэн ялгаа үүссэн. 1989–2004 оны хооронд эргийн мужуудын нэг хүнд ногдох дундаж орлого гурав гаруй дахин нэмэгдсэн бол дотоодын мужуудын иргэдийн дундаж орлого хоёр дахин л өсчээ. Эргийн хотуудын энэ давуу тал цаашид ч хадгалагдах төлөвтэй, орлогын ялгаатай байдал нэмэгдэх хандлагатай гэж үзэж байв (Sachs et al 1996). Хүн амын шилжих хөдөлгөөнд төрийн зүгээс жижиг болон дунд хэмжээтэй хотуудад шилжин суурьшихыг дэмжих болсноор энэ ялгаатай байдал багасаж байна (Wu 2005). Эрэг орчмын мужууд болон эх газрын дотоод мужуудын хоорондын ялгааг Зураг 6-гаас харна уу. Тус улсын хувьд далайн эргийн мужууд нь илүү өндөр орлоготой эсрэгээрээ баруун төв болон баруун өмнөд мужууд нь бага орлоготой байна. 2017 оны байдлаар нийт хөлөөгийн ядуу иргэдийн 53.6 хувь нь буюу 16.34 сая хүн баруун бүсэд амьдарч байна. 2 саяас дээш ядуу хүн амтай 7 муж байгаагаас хамгийн олон ядуу хүн амтай муж нь Гүйжөү болно. Тус мужид 2.95 сая ядуу иргэн амьдарч байна. Харин Шинжианы ядуурлын түвшин 9.9 хувь байгаа нь бүх улсын хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлт болно. Гансу, Гүйжөү, Түвд, Юннань мужуудын ядуурлын түвшин 7 хувиас дээш байв. Баруун бүсийн мужуудын хөдөөгийн ядуурлын дундаж 5.3 байгаа нь төвийн болон зүүн бүсийн мужуудынхаас хамаагүй өндөр байгаа хэрэг юм.

Зураг 6. Хөдөөгийн ядуурлын түвшин, мужаар, 2017



Эх сурвалж: National Bureau of Statistics, Poverty Monitoring Report of Rural China, 2018

Боловсролын чанар ба зардлын ялгаатай байдал. Дэлхийн банкны судалгаагаар нэг цаг үеийн хүмүүс хоорондын төдийгүй үе хоорондын орлогын тэгш бус байдлын нэг гол эх сурвалж нь боловсролын системийн ялгаатай байдал гэж харуулжээ. Боловсролын чанарын тус улсад ихээхэн ялгаатай. Тухайлбал, 1998 онд Бээжин хотод дунд сургуульд суралцаж буй нэг хүүхдэд гаргасан төрийн зардал Гүйжөү муж дахь ижил зардлаас 12 дахин их байсан бол 2001 он гэхэд бүр 15 дахин их болсон. Түүнчлэн боловсролыг ялгаатай байдал нь мужуудын орлогын ялгаатай байдлын эх үүсвэр болохоос гадна орлого багатай мужуудын боловсролын зардал нь өндөр орлоготой мужуудын хөдөлмөрийн нөөцийг бэлтгэхэд зарцуулагдаж байна. Өөрөөр хэлбэл, орлого багатай мужуудын өндөр боловсрол эзэмшсэн иргэд эрэг орчмын өндөр орлоготой мужуудад шилжин суурьших байдал түгээмэл ажиглагдаж байна (Goh et al 2009). Мөн Хятадын

хөдөлмөрийн зах зээлийн хувьд зарим онцлог байна. Тухайлбал, санхүүгийн болон даатгалын зах зээлд ажиллагсдын дундаж цалин хамгийн өндөр бол мал аж ахуй, загас агнуур, ойн аж ахуй, газар тариалангийн салбарт ажиллагсдын цалин хамгийн бага байна. Аж үйлдвэржилт багатай ХАА-д суурилсан бүс нутгуудын хувьд ядуурлын түвшин бусад мужуудтай харьцуулахад өндөр байна.

Хүн ам зүйн бүтцийн өөрчлөлт. 2000 он гараад Хятадын хөдөө нутгийн ядуурлын нэг том шалтгаан нь хүн амын өндөр наслалт болж эхэлсэн (Zhong 2011). 1979 оноос хэрэгжсэн нэг хүүхдийн бодлого нь одоо үед хөдөлмөрийн нөөцийг бууруулах, хүн ам зүйн тэнцвэртэй бус бүтцийг үүсгэх таагүй нөхцөл байдалд хүргэсэн. Иймээс нэг хүүхдийн бодлогыг эргэн харж, 2016 оноос хоёр хүүхдийн бодлого руу шилжсэн.

БНХАУ ядуурлаас ангижруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хүн амын ядууралд орох үндсэн шалтгаануудыг судлан тэдгээрийг арилгахыг нэн тэргүүнд авч үзэн төрийн бодлого хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2018 оны гуравдугаар сард хуралдсан XIII Ардын их хурлын (National People's Congress) эхний хэсэгт ядуурлын эсрэг тэмцэх талаар хэлэлцэн 2017 оны эцэс гэхэд 27 сая гэж тооцоологдож байсан ядуу иргэдээс нэг жилийн дотор 10 саяас доошгүйг нь ядуурлаас ангижруулах зорилт дэвшүүлжээ. Энэ хурлаар ядууралтай тэмцэх ажлын хүрээнд хийгдсэн, хийгдэж байгаа амжилттай үйл ажиллагаануудын талаар дурдсан байдаг. Үүнд:

Хүн амын орлогын албан татварын шинэчлэл. 2005 оноос өмнө хэрэгжиж байсан сарын татвар ногдуулах хамгийн бага орлогын хэмжээ сарын 800 юань байсныг 2011 онд 3500 юань болгож, 2017 он хүртэл үйлчилж байсныг нэг хүнд ногдох ДНБ-ий 78 хувьтай тэнцүүлэх байдлаар шинэчлэн тогтоосон. Ийнхүү бага орлоготой иргэдэд учирч буй татварын дарамтыг арилгах эерэг үр дагавар авчирна гэж үзжээ.

Хөдөлмөрийн зах зээлийн бодлогын өөрчлөлт. 2010 онд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг үлэмжхэн нэмэгдүүлсэн. Улмаар шат дараалсан өөрчлөлтүүдийн үр дүнд 2015 он гэхэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон дундаж цалингийн харьцаа хувийн секторт 51.2 хувьд бусад секторт 31.2 хувьд хүрч, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжиж буй нийгмийн эмзэг давхаргынханд илүү таатай өөрчлөлт хийгдсэн.

Дибao тогтолцоо. 2016 оны байдлаар 45.8 сая хөдөөгийн оршин суугчид (нийт хөдөөгийн хүн амын 7.8 хувь) хамгийн бага орлогын баталгааны тогтолцоонд (minimum income guarantee system) хамрагдаад байна. Үүнээс гадна хөдөөгийн нэн ядуу 4.97 сая оршин суугчид ядууг тэтгэх тусламж (relief assistance for extreme poverty) хүртсэн. Эдгээр нь зөвхөн хөдөөгийн оршин суугчдад зориулагдаагүй бөгөөд 14.9 сая хотын иргэд (нийт хотын хүн амын 1.9 хувь) уг хөтөлбөрүүдэд хамрагдаад байна. Дибao хөтөлбөр нь хэдийгээр орлогын тэгш бус хуваарилалтыг бууруулахад үр нөлөө багатай ч ядуурлаас ангижруулахад маш чухал хувь нэмэр оруулжээ (Li and Yang 2009).

Мэргэжлийн фермерийн бодлогууд (Pro-farmer policies). 2000 оноос хойш хот хөдөөгийн ялгаатай байдлыг бууруулах, ядууралтай тэмцэх зорилгоор БНХАУ-ын Засгийн газраас мэргэжлийн фермерийн цуврал бодлогуудыг авч хэрэгжүүлж эхэлсэн. Эдгээр бодлого нь ХААн салбарт ажиллагсдад чиглэсэн олон тооны шууд татаас, хөнгөлөлтүүд, ХАА-н бүтээгдэхүүний татвар чөлөөлөлт, алслагдмал нутгийн нийтийн үйлчилгээг сайжруулах, нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд үндсэндээ чиглэгдсэн. Энэ төрлийн бодлогууд нь ядуурлыг бууруулах,

фермерүүдийн амьжиргааны түвшинг сайжруулахад чухал хувь нэмэр оруулсан (Hoken et al., 2016; Li et al., 2013).

Нийгмийн хамгааллын тогтолцооны шинэчлэл. Хүн амыг ядууралд өртүүлж байгаа хамгийн том шалтгаануудын нэг өвчлөлийг бууруулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн хөдөөгийн хүн амыг бараг бүхэлд нь хамарсан Шинэ хөдөөгийн хамтарсан эрүүл мэндийн тусламжийн тогтолцоог (New Rural Cooperative Medicare) хөгжүүлэхэд голлон анхаарсан. Улмаар 2016 оны эцэс гэхэд хотын тэтгэврийн суурь хөтөлбөрт 308 сая ажилчдыг хамруулж, хөдөөгийн хүн амыг оруулаад 508 сая иргэнийг суурь тэтгэврийн хөтөлбөрт хамруулжээ. Өнөөгийн ажилчид ирээдүйд орлогын байнгын эх үүсвэртэй болох замаар ядууралд өртөхгүй байх боломжийг нэмэгдүүлсэн.

Бус нутгийн хөгжлийн стратеги ба сангийн бодлогын өөрчлөлт. Эдийн засгийн шинэтгэлийн ихэнх хугацаанд эрэг орчмын мужуудын эдийн засгийн өсөлт баруун мужуудынхаас хамаагүй өндөр байсан нь баруун мужуудад ядуурал илүү их байгаагийн нэг тайлбар болдог. Энэ шалтгааны улмаас 2000 онд Засгийн газраас Баруун нутгийн хөгжлийн стратегийг баталж, тус бүсийн дэд бүтцийг хөгжүүлэхэд олон улсын хамтын ажиллагаа, улсын төсвийн хөрөнгө оруулалтыг үлэмж нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогуудыг түлхүү хэрэгжүүлэхээр болжээ. Тус бодлогуудын улмаас 2000-аад оны дунд үе гэхэд баруун нутгийн хүн амын дундаж орлого мэдэгдэхүйц нэмэгджээ (Li et al., 2014). Үүний зэрэгцээ 2014 оноос эхлэн хотжуулах үйл явцыг эрчимжүүлж, 2020 он гэхэд ойролцоогоор 100 сая иргэнийг хөдөөгөөс хотод шилжүүлэхээр Засгийн газраас ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийж байна.

Ядуурлыг бууруулах бодлогууд. 1980-аад оны дунд үеэс БНХАУ ядуурлын эсрэг бодлогуудыг хэрэгжүүлж эхэлсэн. Ядуурлын эсрэг бодлогууд болон эдийн засгийн өндөр өсөлтийн хавсарсан нөлөөгөөр Хятадын хөдөө нутагт ядуурлын түвшин мэдэгдэхүйц буурчээ (Li et al., 2014). 2016 – 2020 оны хооронд хэрэгжиж байгаа XIII таван жилийн төлөвлөгөөний дагуу бүх улсад сургуулийн өмнөх боловсрол (3 жилийн) болон бүрэн дунд боловсролыг (12 жилийн) үнэ төлбөргүй олгох болсоны дотор ядуурал ихтэй, хотжилт багатай баруун ба төвийн бүсэд илүү анхаарах болжээ. Энэ хөтөлбөрийн хүрээнд сургуулийн насны бүх хүүхдэд (шилжин суурьшигчид, ажилчид, сургууль завсардсан хүүхдүүдийг оруулаад) бүрэн дунд боловсрол олгохоор ажиллаж байгаа аж.

Санхүүгийн үйлчилгээ. Сүүлийн 15 жилийн хугацаанд ядуурлыг бууруулах, орлогын тэгш бус байдлыг багасгах зорилготой олон тооны төрийн санхүүгийн үйлчилгээг үзүүлж байна. Алслагдсан болон хөдөө нутагт төлбөр тооцооны тогтолцоог сайжруулах, тэлэх аргачлалуудыг боловсруулж, шинэ төрлийн санхүүгийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлж, мөнгөн гүйгээг хийх шинэ хэлбэрийн байгууллагуудыг урамшуулах, дэмжих замаар санхүүгийн үйлчилгээг бөглүү нутагт нэвтрүүлсээр байна. Энэ бодлогын үр дүнд АТМ ба мөнгөн гүйлгээний үйлчилгээ үзүүлэгч агентын тоо 2011-2016 оны хооронд хоёр дахин нэмэгджээ.


Дээрх арга хэмжээнүүд нь үндэсний хэмжээнд нийтлэгээр хэрэгжиж байгаа боловч тухайн орон нутгийн онцлогоос шалтгаан өвөрмөц онцлогтой байдлаар хэрэгжиж байна. МУИС-ЭЗХ ба ӨМИС-МУСХ-гийн хамтарсан багийн хээрийн шинжилгээний нэг талбар болох Гүйжөү муж нь өмнө дурдсанчлан хамгийн их ядуу иргэдтэй муж бөгөөд хэрэгжүүлж буй арга хэмжээ нь илүү өргөн хүрээг хамарсан, ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж байна. Энэ өгүүллийн зорилгын хүрээнд бидний хээрийн шинжилгээний талбаруудын нэг болох ӨМӨЗО-ны ядуурлаас

ангигруулах бодлогуудын онцлог болон Хянган аймагт хийгдсэн хээрийн шинжилгээний дүнг харуулахыг зорив.

ӨМӨЗО-д хэрэгжүүлж буй ядуурлын эсрэг бодлого хөтөлбөрүүдийн тойм

Өвөр Монгол Өөртөө засах орон нь БНХАУ-ын гурав дахь том нутаг дэвсгэртэй, 24 сая хүн амтай, аж үйлдвэр өндөр хөгжсөн, ХАА-н хүчирхэг суурьтай бүс нутаг юм. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд ӨМӨЗО-ы эдийн засаг өндөр хурдтайгаар тэлж, улам бүр аж үйлдвэржиж байна. ӨМӨЗО нь 3 аймаг, 9 хотод хуваагддаг, 103 хошуу, шяньтай. Бодит нийт үйлдвэрлэлийн өсөлтийг авч үзвэл 2008 онд БНХАУ (ДНБ-ий бодит өсөлт 9.7 хувь байв) төдийгүй дэлхийд тэргүүлэхүйц өндөр буюу 17.8 хувийн өсөлттэй байсан бол энэхүү өндөр өсөлтөө цаашид хадгалж, 2016 оныг хүртэл улсын бодит эдийн засгийн өсөлтөөс илүү өндөр өсөлттэй байж иржээ. Харин 2017 оны гүйцэтгэлээр эдийн засгийн бодит өсөлт 4.0 хувьтай байсан нь улсын хэмжээний өсөлтөөс бага болжээ (Зураг 7).


Зураг 7. БНХАУ ба ӨМӨЗО-ы бодит эдийн засгийн өсөлт, жилээр



Эх сурвалж: Inner Mongolian Statistical Yearbook 2018

ӨМӨЗО-ы ДНБ-ий бүтцийг авч үзвэл анхдагч үйлдвэрлэлийн салбар буюу ХАА-н салбар 9 хувийг эзэлж байна. Харин гуравдагч үйлдвэрлэлийн салбар буюу хүнд үйлдвэрлэл, уул уурхайн салбарын нийт үйлдвэрлэл жил тутам өссөөр 2018 оны байдлаар 76 хувьд хүрээд байна (Зураг 8).

Зураг 8. ДНБ-ий бүтэц, салбараар, 2018 он



Хэдийгээр эдийн засгийн бүтэц хурдтайгаар өөрчлөгдөн аж үйлдвэрийн салбар голлосон, суурин ахуй давамгайлсан амьдралын хэв маяг бүрэлдэж, хүн амын амьжиргааны түвшин маш хурдтайгаар сайжирч байгаа боловч ядуурлын асуудлууд байсаар байна. 2017 оны эцсийн байдлаар амьжиргааны түвшин доогуур гэж тооцогдсон 57 хошуу, шянь байсны 31 нь улсын тэтгэмжийн зэргийн, 26 нь орны түвшний тэтгэмжийн зэргийн гэж үнэлэгдсэн. 2018 оны эцсийн байдлаар ӨМӨЗО-ы хэмжээнд 676 гацааны амьжиргааны түвшин доогуур байгаа ба бүртгэлтэй ядуу өрхийн тоо 68 мянга, ядуурлын шугамаас доогуур орлоготой хүн амын тоо 152.4 мянга байна. ӨМӨЗО-ы хувьд 2018 онд 37 гацаа, шянийг ядуурлаас ангижруулсан мэдээтэй байна. Үүнээс орны тэтгэмжийн зэргийн бүх хошуу, шянийг, улсын тэтгэмжийн зэргийн 31 гацаанаас 11-ийг нь ядуурлаас ангижруулжээ. 2020 он гэхэд амьжиргааны түвшин доогуур бүх хошуу, шянийг ядуурлаас ангижруулах төлөвлөгөөтэй. Хятадын хувьд ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай өрхүүд, хувь хүмүүсийг дан дангаар нь ядуурлаас гаргахаас илүүтэйгээр гацаа, тосгоноор нь хамтад нь бүлгэмдэн ядуурлаас гаргах онцлогтой гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.


Хүснэгт 1.ӨМӨЗО-ы хошуу ба шяны тоо, амьжиргааны түвшинээр

Нийт хошуу, шяны тоо	103		
Үүнээс: Амьжиргааны түвшин доогуур	57	2018 оны эцсийн байдлаар ядуугаас ангижруулсан	
Улсын тэтгэмжийн зэргийн	31		11
Орны тэтгэмжийн зэргийн	26		26

Эх сурвалж: ӨМӨЗО-ы Ядуурлыг бууруулах ажлын хөтөлбөр, 2019

Ядуурлын шалтгааныг Зураг 9-т харуулав. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой хүн амын 2/3-оос илүү нь хүнд өвчин, түүний эмчилгээний зардалтай холбоотой шалтгааны улмаас ядууралд өртсөн. Иймээс ӨМӨЗО төдийгүй бүх Хятад улс даяар эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэтгэн сайжруулах, бүх иргэдэд хүртээмжтэй болгох, нэн ялангуяа хүнд өвчин туссан иргэдэд илүүтэй хөнгөлөлт үзүүлдэг, урьдчилан сэргийлэх үзлэгт иргэдийг тогтмол хамруулдаг болгохоор далайцтай ажиллаж байна. Дараагийн том шалтгаан нь хөгжлийн бэрхшээлтэй холбоотой, эсвэл өрхөд хөдөлмөрийн чадвартай гишүүн байхгүйтэй холбоотой.

Зураг 9. Ядуурлын шалтгаан, эзлэх хувиар



Эх сурвалж: ӨМӨЗО-ы Ядуурлыг бууруулах ажлын хөтөлбөр, 2019

Түүнчлэн хангалттай түвшний боловсрол эзэмшээгүйгээс ядууралд өртөх явдал их байна. Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 4.1 хувь нь боловсролгүйн улмаас ядууралд өртсөн. Түүнчлэн байгалийн гамшигт үзэгдлээс шалтгаалан ядууралд өртсөн иргэд багагүй хувийг эзэлж байна. Иймээс ядуурлаас гаргах бодлого, хөтөлбөрүүдэд аюултай бөгөөд чанарын шаардлага хангахгүй орон сууц, байшинг засварлах, хүчитгэх, шинээр барьж иргэдийг шилжүүлэн суулгах ажлуудыг тусган оруулсан. Хөрөнгө мөнгөний дутагдалтай байдлаас үүдэн ядууралд орох явдал 4.1 хувийг эзэлж байна. Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилготой хэд хэдэн ажлууд хийгдэж байгаагийн зэрэгцээ шинэ төрлийн санхүүгийн арга хэрэгслүүдийг хөдөө, алслагдмал нутгуудад нэвтрүүлэх байдлаар бизнес эрхлэгчид, мөнгөн хөрөнгийн хэрэгцээ бүхий иргэдэд таатай нөхцөл байдал үүсгэхээр ажиллаж байгаа аж.

ӨМӨЗО-ы хувьд зүүн хэсгийн аймаг, хотууд хүн амын нягтшил өндөр, тариалах аж ахуй давамгайлсан шинжтэй байдаг. Уг хэсэгт байх Улаанхад, Улаанцав, Тонглюа, Хянган аймгуудад ӨМӨЗО-ы нийт хүн амын 46 хувь нь амьдарч байгаа боловч амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн 90.5 хувь ногдож байгаа нь тухайн аймаг, хотуудын хувьд амьжиргааны түвшин доогуур байгааг харуулж байна.

Хүснэгт 2. ӨМӨЗО-ы хүн амын бүтэц, хувиар

	ӨМӨЗО -ы хүн амд эзлэх хувь	ӨМӨЗО-ы амьжиргааны түвшин доогуур хүн ам
Улаанхад, Улаанцав, Тонглюа ба Хянган	46%	90.5%
Бусад	55%	9.5%

Эх сурвалж: ӨМӨЗО-ы Ядуурлыг бууруулах ажлын хөтөлбөр, 2019

ӨМӨЗО-ы хэмжээнд ядуурлыг бууруулах ажлыг төв Засгийн газрын тодорхойлсон хүрээнд өөрийн онцлогт тохируулан засварлах байдлаар хэрэгжүүлж байна. Энд “Хоёрт үл зовж, гурвыг баталгаажуулах” гэсэн зорилт дэвшүүлж, гурван жилийн хугацаанд хэрэгжүүлэх ядууралтай тэмцэх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалт, бичил зээлийн шинэ, илүү сайн тогтолцоотой болохоор ажиллаж байна. Түүнчлэн Төв Засгийн Газартай гурван жилийн хугацаатай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр болжээ. Ядууралтай тэмцэх ажилд 2013-2017 оны хооронд нийтдээ 26.1 тэрбум юанийн хөрөнгө оруулалт хийгдсэний 35 хувийг нь Төв Засгийн Газар, 36 хувийг ӨЗО-ы удирдлага, үлдэх хэсгийг орон нутгийн захиргаанаас гаргажээ.

“Хоёрт үл зовж, гурвыг баталгаажуулах” гэсэн зорилтын хүрээнд дараах бүлэг ажлуудыг гүйцэтгэж байна. Үүнд:

- Үйлдвэржилтийн түвшнээс үүдэлтэй ядуурлыг бууруулж, улмаар хөдөлмөрийн чадвартай ядуусын орлогын эх үүсвэрийг баталгаажуулах, нэмэгдүүлэх;
- Нийгмийн халамжийн бодлогыг зорилтот бүлэгт илүү өгөөжтэй байдлаар сайжруулах;
- Заавал олгох бүрэн дунд боловсролын хүртээмжийг 100 хувьд хүргэх, сургуулиас гарах, сургууль завсардах явдлыг арилгах, боловсрол хүртэхэд шаардлагатай суурь дэд бүтцийг бий болгох, чанарыг сайжруулах;
- Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар ядуурлын үндсэн шалтгаануудын нэгтэй тэмцэх;
- Чанарын шаардлага хангахгүй, аюултай орон сууцыг сайжруулах, солих, амьжиргааны түвшин доогуур иргэдийн орон сууцыг засварлах, шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх, шинэ орон сууцанд нүүлгэн шилжүүлэх;

- Ундны усны чанар, аюулгүйн стандартыг баримтлах, түгээлтийн системийг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Ядуу иргэдэд илүү ээлтэй санхүүгийн бүтээгдэхүүнийг хөгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Төв Засгийн Газрын дэмжлэгийг авах замаар хөрөнгө оруулалтын нэмэлт эх үүсвэрийг татах, шилдэг туршлагыг нэвтрүүлэх, иргэдийг ухамсар, мэдлэг, урам зоригийг нэмэгдүүлэх замаар ядууралтай тэмцэх;
- Ядууралтай тэмцэх ажлыг бүх шатны нам, төрийн албан хаагчдын гол ажлуудын нэг болгон тодорхойлж, хамтын хүчээр богино хугацаанд даван туулах;
- Амьжиргааны түвшин доогуур иргэдэд мэдлэг олгох, ойлгуулах, үлгэрлэх, заах боломжит бүх арга замыг ашиглан хувь хүний ядуурлаас гарах хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх гэсэн олон тооны аргыг ашиглаж байна.

Ядууралтай тэмцэх ажилд зөвхөн төрийн байгууллагын хүч, хөрөнгийг дайчлаад зогсохгүй хувийн хэвшлийн байгууллагуудыг нийгмийн хариуцлагын хүрээнд амьжиргааны түвшин доогуур иргэдэд туслах, дэмжлэг үзүүлэх нөхцөл байдлыг тодорхой, ядуурлыг бууруулах ажилд идэвхтэй оролцож байгаа байгууллагуудыг урамшуулах, бага оролцоотой байгууллагад шахалт үзүүлэх замаар эдийн засгийн идэвхтэй бүх нэгжүүдийг энэхүү компанит ажилд татан оролцуулж байгааг дурдах хэрэгтэй. Өгүүллийн дараагийн хэсэгт ӨМӨЗО-ы Хянган аймгийн Хорчин баруун гарын дундад хошуунд ядуурлаас ангижруулах бодлогыг хэрэгжүүлж буй байдалтай танилцсан тоймыг оруулав.

Хянган аймгийн Хорчин баруун гарын дундад хошуунд хэрэгжүүлж буй ядуурлаас ангижруулах ажлын жишээ

Хорчин баруун гарын дундад хошуу нь Их Хянганы нурууны өмнөд хэсэгт байрладаг, нийт газар нутгийн хэмжээ 15.6 мянган км², үүнээс тариалангийн газар 4.5 сая га, бэлчээрийн газар нутаг нь 13.0 сая га, ой мод 4.1 га газрыг тус тус эзэлдэг. Хошуу нь 12 сум, 173 гацаа, 26 багтай. Хошууны нийт хүн амын тоо 252.7 мянга бөгөөд үүнээс 86.6 хувь нь Монгол үндэстэн байгаа нь тус хошууг ӨМӨЗО-ы хамгийн их Монгол үндэстэнтэй хошуу болгож байна. 1988 онд Хорчин баруун гарын дунд хошуу нь улсын зэргийн ядуурлын бүс хэмээн бүртгэгдэж, 2011 онд мөн Daxing anling Nanxun-ийн онцгой ядуу бүс хэмээн тодорхойлогдсон бөгөөд 2013 оны 11 дүгээр сард Коммунист намын XVIII их хурлаар БНХАУ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ши Жиньпин Хорчин баруун гарын дундад хошуунд ядуурлыг бууруулах, ядуурлаас ангижрах, хөгжлийн шинэ үе шатыг хамтдаа туулах арга замыг эрэлхийлэх талаар дурдсан нь тус хошууг олон нийтийн анхаарлын төвд оруулсан. Мөн ядуурлыг бууруулахад хэрэгжүүлж байгаа аливаа төсөл нь нарийн зохион байгуулалттай, санхүүжилтийг зөв зохистой ашиглах, ядуурлыг зөв тодорхойлж яг тохирсон арга хэмжээг авах, ядуурлыг бууруулах, хөнгөвчилөх үйл явцыг боловсронгуй болгох шинэ загвар гаргаж мөрдөх, "ядуурлыг бууруулах үйлдвэрлэлтийг хөгжүүлэх, ядууралд нэрвэгдсэн газар нутгийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх, ядуурлыг бууруулах экологийн нөхөн төлбөр олгох, ядуурлыг бууруулах боловсролыг хөгжүүлэх зэрэгт чиглэж байна. Нийгмийн хамгааллын хүрээнд ядуурлыг бууруулах тогтвортой байдлыг хангах талаар "хэнд туслах вэ?", "хэрхэн туслах вэ?", "аяж хэрэгжүүлэх вэ?" гэдэг логик уялдаагаар ажиллаж, ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд нам, төрийн байгууллагууд онцгойлон анхаарах болжээ. Түүнчлэн нийтээрээ хоол хүнсэнд санаа зовохгүй байх, хувцас хунарт санаа зовохгүй байх, суурь боловсрол эзэмших, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ авах, орон байрны баталгаа гаргах гэсэн үндсэн суурь үзүүлэлтүүдээр бодит, шуурхай, нэгдсэн ажлуудыг хийж байна. Ядуурлыг бууруулах талаар логик зураглал хийх, цагийн хуваарь гаргах, ядууралд нэрвэгдсэн бүс нутагт хамгийн түргэн, яаралтай төслүүдийг тодорхойлж хийж хэрэгжүүлснээр тухайн бүсийн хөгжлийн төлөвлөлт цэгцэрч, дэд бүтэц болон барилга байгууламж, аж үйлдвэрийн хөгжил, төрийн үйлчилгээ, тосгоны байгаль экологийн орчин, ядууралд өртсөн айл өрхүүдэд тэргүүлэх ач холбогдол өгнө гэж ХКН-ын XIII хуралд тэмдэглэгджээ.

Уг хошуунд 8,465 өрх буюу 22305 иргэн ядууралд нэрвэгдсэн гэж тооцоологдсон бөгөөд 2019 оны эхний улирлын байдлаар 7912 өрх буюу 20,856 иргэн ядуурлаас гарч, 1449 иргэн амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур гэж үнэлэгдэж байна. 2020 он гэхэд бүх иргэдээ ядуурлаас гаргахаар ажиллаж байна. Энэ хошууны үндсэн зорилго нь гацаа тус бүрийг бүхэлд нь ядуурлаас ангижруулах явдал бөгөөд ядуурлын шугамаас дээш орших өрхийн тоо 97 хувиас давсан бол ядуурлаас ангижирсанд тооцож байна. Хорчин баруун гарын дундад хошуунд төрөөс тэтгэлэг олгон нутгийн ядуу иргэдэд өөрийн хүчээр ядуурлаас гарах үндсэн арга ухааныг суулгаж, ядуурлын шалтгааныг тогтоож тохирсон арга хэмжээг тус бүрт нь өөр өөрөөр шийдэж ядуурлаас гаргах, амьдралын наад захын хэрэгцээ шаардлагаа хангах чадамжтай болгох зэрэг олон төрөл зүйлээр ядуу иргэдээ дэмжиж, ахар богино хугацаанд олон өрх, иргэнийг ядуурлаас гаргаж байна. Тус хошуунд ядуу иргэдээ татан оролцуулсан зонхилох үйлдвэрлэл аж ахуй нь Фермерийн аж ахуй бөгөөд үхэр, хонь үржүүлэх, уран хатгамлын үйлдвэрлэл эрхлэх, үйлдвэрлэлийг дэмжих, элэгдэлд орсон газрыг ойжуулж, жуулчдыг татах, ядуу иргэдийг гар урлалын сургуульд үнэ төлбөргүй сургаж ажил орлоготой болгох зэрэг ажлууд зонхилон хийж байна. Мөн Бүх Хятад улсад цаашлаад дэлхийн стандартад нийцэхүйц махны чиглэлийн үхэр үржүүлэг болон борлуулах худалдааны нэгдсэн төв, хурдан удмын морины CaiDe Ma Group,

Түшээт вангийн уран хатгамлын нийгэмлэг зэрэг ядуурлыг бууруулахад нийгмийн хариуцлагаа ухамсарлаж, тэргүүлэн оролцож байгаа байгууллагуудын үйл ажиллагаатай танилцав.

Сүүлийн жилүүдэд Хорчин баруун гарын дундад хошууны ядуурлыг бууруулахад чиглэсэн ажиллагаа нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн ерөнхий чиг хандлагад өөрчлөлт оруулах "Таван багц", "Зургаан зүйл"-ийн шаардлага гэгчийг боловсруулан, ядуурлыг бууруулах ажилдаа мөрдлөг болгон хэрэгжүүлснээр жишиг болохуйц үр дүнд хүрсэн. Ядуурлаас гаргах "таван багц" гэдэгт: 1. Үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, 2. Нүүлгэн шилжүүлэх, 3. Экологийн тэнцвэрт байдлыг хангах, 4. Боловсрол олгох, 5. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэсэн үйл ажиллагаануудыг оруулж байгаа бол "Зургаан зүйл" гэдэгт: 1. Ядууралд хэн өртөж байгааг нарийн тогтоох, 2. Төсөл хөтөлбөрүүдийг нарийн зохион байгуулах, 3. Санхүүжилтийг зөв зүйтэй зарцуулах, 4. Орон байр, амьдрах нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах, 5. Тосгоныг төгөлдөржүүлэх, 6. Ядуурлыг бууруулахад гарсан үр дүнг нарийн тооцох гэсэн үйл ажиллагаануудыг оруулдаг.

2017 оноос эхлэн тариаланч, малчдын үйл ажиллагаа эрхлэх чанарыг сайжруулах төслийг "нэг сургалт, нэг бүс, хоёр ээлж, гурван шинэчлэл" гэсэн агуулгатайгаар хийж ирсэн. Энэ нь ядуурлыг бууруулах, хөдөөгийн сэргээн босголтыг сайжруулахад чухал эхлэлийн суурь болж чадсан юм. Мөн иргэдийн нийгмийн үзэл суртлын талаарх ойлголт сайжирч, ухамсар дээшлэхийн хэрээр олон хүн "би ядуурлаас гарахыг хүсэж байна" гэсэн сэтгэлгээг өөртөө баг суулгаж ядуурлаас ангижирч буй нь анхаарал татахуйц онцлох зүйл байв. Тосгодод хүн амын суурьшлыг шинэчлэх ажлыг бүх шатанд явуулсан бөгөөд тосгон, тосгоны дүр төрх ихээхэн өөрчлөгдөж ирсэн. Үүнд: Тосгоны зөвлөл, Тосгоны дүрэм, Улаан ба Цагаан зөвлөл, Ёс суртахууны зөвлөл байгуулж, зөвлөлөөрөө шийдвэрлэн мөрийтэй тоглоом, мансууруулах бодис, хар тамхины эсрэг "нэг зохицуулалт, дөрвөн бага хурал" гэсэн чиг үүргээр хяналт тавьж, бүс нутгийн онцлогтой зан заншлаа гүнзгийрүүлэн хөгжүүлж, тосгоны соёл иргэншилд шинэ уур амьсгалыг төлөвшүүлснээр ядуурлыг бууруулахад хүнд ойр, хэрэгжүүлэхэд дөхөм шалгарсан арга болсон гэж нутгийн удирдлагууд үзэж байв.

Түшээт вангийн ордны уран хатгамлын гар урлалын үйлдвэрлэл. Чин улсын үеийн Хорчины Түшээт вангийн ордонд дэг ёс, уран хатгамал, оёдлын үйлдвэрлэлийн өвийг хадгалсан нь өнөө үед давтагдашгүй өвөрмөц хэв маягтай гэж алдаршжээ. Энэхүү өв соёл бараг устаж үгүй болж байхад нь нутгийн захиргааны зарим ажилтнуудын санаачилгаар дахин сэргэх болжээ. Тус уран хатгамал нь өвөрмөц, уламжлалт урлагийн арга техниктэй гэсэн үндэслэлээр 2009 онд хоёр дахь бие даасан бүс нутгийн биет бус соёлын өвд багтжээ. 2016 оны 12-р сард Түшээт хааны хатгамлын үйлдвэрийн ядуурлыг бууруулах зөвлөлийг байгуулж, 2017 оны 7-р сард Коллежийн оюутнуудын бизнес эрхлэлт, ажил эрхлэлтээр ядуурлыг бууруулах үйлчилгээний холбоо байгуулан "аж ахуй, нийгэмлэг, ядууралд өртсөн өрхүүдийн хөгжлийн загвар"-ыг боловсруулсан. Энэ нь одоо цагийн ядуурлыг бууруулахад ордны хатгамлыг хэрэглэсэн анхны тохиолдол болжээ. Одоогийн байдлаар 50 гаруй оюутан ажил эрхлэлт, ажил эрхлэлтийг дэмжих яамны ядуурлыг бууруулах үйлчилгээний холбоонд нэгдээд байна. Оюутнууд өөрсдийн бүтээгдэхүүнийг сурталчилах, хөгжүүлэх төв, борлуулалтын төвүүдийг байгуулж, хатгамал дизайны загвар, бүтээгдэхүүний захиалга, цахим худалдаа, онлайн борлуулалт зэргийг гүйцэтгэх нарийн зохион байгуулалттай багийг бүрдүүлжээ. Сонирхолтой нь бараг мартагдаж байсан Түшээт вангийн ордны хатгамалын урлагийг сэргээхийн тулд эхэн үедээ суралцагсдын чанарын шаардлага хангахгүй байгаа бүтээгдэхүүнийг уг сургалтын төв өөртөө худалдан авч, анхлан суралцагчдад зориудаар урамшуулал үүсгэн улам илүү хичээл зүтгэлтэйгээр суралцах боломжийг нээж өгснийг тэмдэглэх хэрэгтэй. Суралцагсдын хувьд заавал ядуу өрхийн гишүүн байх албагүй бөгөөд суралцахыг хүссэн хүн бүрт нээлттэй, үнэ төлбөргүйгээрээ онцлог байв.

1200 м.кв талбайтай Түшээт хааны хатгамлын үйлдвэрийн ядуурлыг бууруулах сургалтанд өдөр тутам 600 гаруй ядуу тариачид, малчид хамрагдаж, хатгамалын урлагт суралцдаг. Ядуу өрхүүдийн бүтээгдэхүүнийг зарсны дараа ядууралд нэрвэгдсэн айл өрхүүдэд газар дээр нь тооцоо хийж, мөнгө шилжүүлж, зарим тохиолдолд ур чадвар, бүтээгдэхүүний чанараас шалтгаалан сар бүр цалин өгдөг. Ихэнх ядуу өрхүүд өнгөрсөн жилүүдэд 10,000 гаруй юаниар орлого олсон бөгөөд ажилдаа маш идэвхтэй байдаг гэнэ. 2018 оны байдлаар Хорчин баруун гарын дундад хошууны 173 гацааны 10,000 гаруй тариаланч, малчид сургалтанд хамрагдсан. 2019 оны эхэн үед 21,000 гаруй ядуу эмэгтэйчүүд хатгамлын салбарт оролцож, 12 аж үйлдвэрийн тосгон бүрдүүлж, ядуурлаас бүрэн ангижирч чадсан бөгөөд хүн бүр жилд дунджаар 2000 юаниар орлогоо нэмжээ.

Зах зээлийн хэрэгцээ шаардлагын дагуу Түшээт хааны хатгамлын ядуурлыг бууруулах сургалт нь гар урлал, жижиг гоёл чимэглэл, энгийн загварын хатгамал, даавуун уут, уламжлалт угсаатны загвартай гоёлууд, дэр, ширээний туг, орон орны туг далбаа зэргийг дотоод гадаадын зах зээлд борлуулж, үйлдвэрлэх, худалдах үйл ажиллагааг эрчимтэй хөгжүүлсээр байна. Үндэстний өвөрмөц онцлогтой, орчин үеийн гоо зүйд нийцсэн загварлаг дизайнтай, хатгамлын бүтээгдэхүүнийг Хөх Хот, Шэньян, Бээжин, Хонг Конг, Солонгос зэрэг улс руу экспортолож байна.



Өвөр Монголын LaiDe MaYe группын адуу үржүүлгийн төв. Тус хошуунд адуу үржүүлгийн төвийг 2006 онд байгуулсан бөгөөд Монголын уламжлалт морин уралдаан, тойруулгын уралдаан, орчин цагийн адууны сайн үүлдрийг өсгөхийг зорин ажиллаж байна. Мөн мал аж ахуйн бүтээгдэхүүн борлуулах нэгдсэн төв, ногоон аялал жуулчлал, соёлын бааз зэрэг салбарт хийсэн хөрөнгө оруулалтаараа тус хошуунд тэргүүлсэн анхны хувийн аж ахуйн нэгжүүдийн нэг юм. Тус группын адууны тэжээлийн үйлдвэр, морин уралдааны клубын барилгын ажилд маш их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд үүнд Райдер Спортын морин худалдааны зах зээл, тэжээлийн аж ахуй, худалдааны төв, тойруулга, сургалтын төв гэх мэт байгууламжийг барьжээ. Энэ компанийн дундад хошуунд байрлах салбарт 4500 гаруй өндөр чанарын адуутай, үүнээс 1242 цэвэр цустай адуутай. Жилд ойролцоогоор 10,000 тонн тэжээл орон нутгийн зах зээлээс худалдан авдаг. Тус компани нь нийт 1200 ажилтантай үүнээс 800 гаруй нь орон тооны ажилчид юм. Орон нутгийн засаг захиргаатай хамтран ядуурлыг бууруулах хоршоодыг байгуулж, ядуурлаас гарах ажлыг зохион байгуулж ядуу, ажилгүй, орлогогүй, тариаланч малчдыг байнгын ажлын байртай болгох, тасралтгүй орлоготой дэмжлэг үзүүлэх замаар нийгмийн хариуцлагаа ухамсарлан ажиллаж байна.

Орон нутгийн ядуурлыг бууруулахад оруулж буй тус компанийн хувь нэмэр нь зөвхөн ӨМӨЗО-д алдаршаад зогсохгүй, бүх Хятад даяар сурталчилагдан, кино, урлагийн оддын анхаарлыг татаж, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх талаарх ухуулга сурталчилгааны жишээ болжээ. Тухайлбал, 2018 онд ССТВ-ийн "Ядуурлыг бууруулах тулалдаан ба Оддын үйл ажиллагаа" нэртэй нэвтрүүлэгт гол сэдвээр сонгогдон бүх улс даяар цацагджээ. Хорчин баруун гарын дундад хошууны ядуурлыг бууруулахад зориулж, "Ядуурлыг бууруулах таван загвар"-ыг

шинэчлэн гаргаж, амжилттай хэрэгжүүлсэн нь ийнхүү нэрд гарах шалтгаан болжээ. Энэхүү загвар нь дараах байдалтай байна.

1. *Бизнесийн загварыг оруулах загварчлал.* Малчин болон тухайн группийн хооронд группийн дүрмийн дагуу морь үржүүлгийн бизнес хийнэ.
2. *Хөрөнгийн орлогын загварчлал.* Компани өөрийн хувьцааны 10 хүртлэх хувийг хөдөлмөрийн чадвараа алдсан ядуу иргэдэд төрөөс олгосон тэтгэмжинд тааруулан худалдах бөгөөд жилд 2 удаа 5 хувиар ногдол ашиг хүртэх, иргэн хүсвэл компани хувьцаагаа буцаан худадан авах байдлаар орлого олох боломжийг бүрдүүлжээ.
3. *Дахин боловсруулах горимын загварчлал.* Гацаа тосгонуудад хүрч ажиллаж, нээлттэй хаалганы ажиллагаа зохион байгуулж, орон нутгийн иргэдийн адуун сүргийн чанарыг сайжруулах. Удам сайжирсан адуун сүргийг зах зээлийн үнээс өндөрөөр худалдан авах. Энэ нь ядуу иргэн дунджаар 4000-7000 юаний орлоготой боломжийг олгодог аж.
4. *Ажлын уян хатан загвар.* Морин уралдааны үндэсний тэмцээн жил бүр зохион байгуулдаг. Жил бүрийн үндэсний тэмцээнүүдэд ядуу хүмүүсийг түр ажлын байраар хангах нь маш ач холбогдол өгдөг. Ихэнхдээ 1500 гаруй түр ажилчин ажил эрхэлдэг бөгөөд нэг хүнд ногдох орлого 3500-4000 юань хүрдэг аж.
5. *Үндсэн горимын загварчлал.* Газар тариалан болон өвс гэжээлийн хангамжийг орон нутгаас татан авах, тэр тусмаа амьдарлын боломж багатай иргэдээс худалдан авах гэсэн 5 загварчлалын аргаар ядуурлыг бууруулж байна.



Тус Групп нь Хорчин баруун гарын дундад хошууны засгийн газар ядууралд нэрвэгдсэн 3600 ядуу хүнийг ядуурлаас гаргасан амжилтаараа ӨМӨЗО-ы "Ядуурлыг бууруулах тэргүүлэх түвшний аж ахуйн нэгж", "хувийн шилдэг аж ахуйн нэгж" гэсэн үнэлгээ шагнал хүртсэн.

Хорчин баруун гарын дунд хошууны мэргэжил боловсролын сургууль. Тус сургууль нь 1983 онд байгуулагдсан бөгөөд нийт 160,000 метр квадрат талбайг хамарсан сургалтын цогцолбор байгууламжтай, нийт 532 оюутан, 74 багшийн бүрэлдэхүүнтэй. Тус сургууль нь гоо сайхны салон, зураг урлал, чимэглэл, Монгол мал аж ахуй, автомашины хэрэглээ, засвар үйлчилгээ, хөдөө аж ахуйн машин механизмын судалгаа, морин хуур хөгжим зэрэг есөн мэргэжлээр лаборатори болон танхимын сургалтаар хичээл заадаг. Жил бүрийн мэргэжлийн бус сургалтанд 500-аас дээш хүн, хамтарсан сургалтанд 3100 дээш хүн хамрагддаг байна. Хорчин баруун гарын дундад хошууны Төв хорооны төрийн нэгдсэн зохицуулалт дор тус боловсрол мэргэжлийн сургууль нь "боловсролоор ядуурлыг бууруулах", "фермерүүд, малчдын чанарыг сайжруулах" тэргүүлэх чиг үүрэгтэйгээр ажиллаж байна. "Ур чадварын сургалт", "оршин суугчдын харилцан туслалцаа" нь тариаланч, малчдын ядуурлыг бууруулах, чанарыг сайжруулах арга замыг цогц байдлаар тодорхойлсон бөгөөд ялангуяа Бээжин-ӨМӨЗО-ы хамтын ажиллагааг хэрэгжүүлэх нэг

талбар болох боловсрол, мэргэжлээр ядуурлыг бууруулахад хувь нэмрээ оруулж байна. Тус сургууль нь мянга мянган ажилчдыг сургах, ажлын байртай болгох, нийгмийн сайн сайхныг сурталчилан таниулах, ажлын байрны дарамтыг багасгах, оюуны санааны ядуурлыг багасгах, фермер, малчдын чанарыг дээшлүүлэх зорилгоор хоёрдогч мэргэжлийн сургууль, сургалтын төв байгуулан ажилласан нь тус хошуундаа ядуурлыг бууруулахад үнэтэй хувь нэмэр оруулсан гэж албаны хүмүүс дүгнэж байв. Уг мэргэжлийн сургалтын төв нь ядуу иргэдийг нэг сарын хугацаатай 5 төрлийн мэргэжлийн сургалтанд үнэгүй хамруулдгаараа онцлог байв.

Дүгнэлт

БНХАУ-д хэрэгжиж байгаа бодлого хөтөлбөрүүдийн ерөнхий байдал, ядуурлын дүр зургаас тоймлон харвал бусад улсуудад жишиг болохуйцаар амжилттай хэрэгжүүлж байгааг юуны өмнө дурдах хэрэгтэй. Нэн ялангуяа Монгол улсын хувьд тал бүрээр нь суралцах, танилцах хэрэгтэй. Хээрийн шинжилгээний ажлаас дараах дүгнэлтүүд гарч байна.

1. БНХАУ-ын Ядуурлаас ангижруулах аливаа бодлогыг хэрэгжүүлэхээс өмнө заавал нарийвчилсан судалгаа хийж, тухайн нутгийн онцлогийг заавал харгалзан үзсэн байдалтай, харьцангуй уян хатан шинжтэй зохиогддоогоороо давуу талтай байна. Тухайн нутгийн онцлог байдлыг сайтар судалсан, төрийн бодлогын суурь судалгаа нь ядуурлаас ангижруулах бодлогуудыг амжилттай хэрэгжих үндсэн нөхцөл болж байна. Жишээлбэл:
 - Тонгляо хотын Усан гацаанд элсэн манханг ногооруулах төслийнхөн Хайлаар нарс (тус нутгийн уугуул ургамал биш) авчирч суулгасан нь амжилттай болсон.
 - Гүйжөү мужийн Аншун хотын нэгэн тосгон өөр газраас авчирсан нэгэн төрөл жимсийг нутагшуулан ургуулсан нь амжилттай бизнесийн эхлэл болсон.
 - Гүйжөү мужийн Хуйшуй хотын алслагдмал тосгон суурингуудад нутгийн иргэдийн тариалж дадсан “Бурханы мутар” хүнсний ногоог дагнан тариалуулснаар үйлдвэрлэлийн бүтээмж нэмэгдэж, тариачдын орлогын түвшин эрс дээшилсэн.
 - Тонгляо хот нь Хятад улсад алдартай Хорчины улаан үхрийг өсгөх замаар ядуурлаас ангижрах явдлыг дэмжих болсон.
 - Хянган аймгийн Түшээт вангийн ордоны хатгамалын урлалыг түгээн дэлгэрүүлэх, үйлдвэрлэл – борлуулалтын цогц сүлжээг бодлогоор дэмжсэн гэх зэрэг нь онцлохуйц жишээ байв.
2. ӨМӨЗО ба Гүйжөү мужийн аль аль нь аливаа бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ цогц системлэг байдлаар хандаж, хамаарал бүхий бүх асуудлуудыг шийдвэрлэхийг зорьж байгаа нь чухал ач холбогдолтой арга зам гэж үзэж байна. Тухайлбал:
 - Гүйжөү мужийн Хуйшуй хотын Их өгөгдлийн шинжилгээний инкубатор төвийг байгуулахдаа дэд бүтцээс эхлээд ажиллах хүч бэлтгэх сургууль хүртэл бүх хүчин зүйлсийг тооцож, нэг дор төвлөрүүлэн цогцолбор хэлбэрээр байгуулсан.
 - Аншуны ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэл–хадгалалт–түгээлт–борлуулалтын цогц сүлжээ буюу өртгийн сүлжээг байгуулсан.
 - Хорчины улаан үхрийн аж ахуйг хөгжүүлэхдээ Симменталь үүлдрийн үхрээр сайжруулан нутгийн шилмэл цөм сүргийг байгуулсан бөгөөд айл өрхүүдэд хэрхэн маллахыг зааж, хашаалах мал аж ахуйг эрчимжүүлэхийн зэрэгцээ дундын зуучгүйгээр өндөр үнээр борлуулах боломжийг малчдад олгох мал худалдаалах төвийг байгуулсан явдал нь үүний жишээ болно.
3. Аливаа бодлогыг хэрэгжүүлэхдээ нам, төрийн албан хаагчид төдийгүй энгийн иргэд ч ойлгоход хялбар байдлаар томъёолон хүргэдэг нь энгийн боловч оновчтой арга зүй мэт санагдав. Жишээлбэл,
 - “Хоёрт үл зовж, гурвыг баталгаажуулах” хөтөлбөр
 - “6 дэвшсэн тосгон” хөтөлбөр
 - “676” хөтөлбөр гэх мэт
4. Ядуурлаас ангижруулах хөтөлбөрүүд нь еөрнхийдөө өрхүүдийн ядууралд өртөж байгаа үндсэн шалтгаанууд, уг үндэстэй нь тэмцэхэд чиглэсэн бөгөөд ядуурлаас гарсан өрх цаашид эргэн ядуурахгүй байх талаар анхаарч байгаа нь чухал ач холбогдолтой гэж үзэж

болно. Ядуу өрхийн хүн амын амьдралын орчныг дээшлүүлэх, мэдлэг олгох, урам зориг төрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байгаа нь сонирхолтой санаачилга байв. Ядуурлын тойргоос өрхүүдийг гаргахын тулд хүүхдүүдийн боловсролд ихээхэн анхаарч үнэ төлбөргүй суурь боловсрол олгох, нэн хөнгөлөлттэй нөхцөлөөр дээд боловсрол олгож буй нь маш чухал санаачилга болжээ.

5. Хүн амыг ядуурлаас ангижруулах үүргийг зөвхөн төр үүрэх бус харин ч энэ ажлын хүрээнд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудыг татан оролцуулах талаар санаачилгатай ажиллаж байгаа нь ихээхэн анхаарал татаж байв. Хувийн хэвшлийн томоохон аж ахуйн нэгж байгууллагуудын нийгмийн хариуцлагын хүрээнд хийж байгаа ажлуудыг ядуу өрхүүдийн амьдралын нөхцөлийг сайжруулахтай ямар нэг байдлаар холбож байгаа нь онцлууштай байв. Жишээлбэл,
 - Хянган аймаг дахь адуу үржүүлгийн газар нь үндсэн үйл ажиллагааныхаа хүрээнд ядуу өрхийг олон янз байдлаар дэмжиж байна.
 - Хуйшуйгийн их өгөгдлийн шинжилгээний инкубатор төв нь боловсролын олгох олон талын дэмжлэгийг ядуу иргэдэд үзүүлдгээрээ давуу талтай.
6. Аливаа хөтөлбөр, бодлогын хэрэгжилтийг шалгаж буй байдал нь анхаарал татаж байна. Намын боловсон хүчний мэргэжилтнүүд 14 хоног тутам ядуу өрхүүдээр орж бодлого хэрхэн хэрэгжиж байгааг шалгах бөгөөд тэдгээрт гүйцэтгэж болох, гүйцэтгэж чадах даалгавар, үүрэг өгдөг нь онцлон үзэх зүйл мөн. Үүгээр зогсохгүй өгөгдсөн үүрэг, даалгаврыг зарим тохиолдолд өөрчлөх, засварлаж болдгоороо давуу талтай юм. Энэ нь тухайн бодлогын хэрэгжилт орон нутгийн онцлогоос болж удааширч байгаа бол тухай бүрт нь тохируулан засварлаж сайжруулах боломж олгодог.
7. Ядуурлаас ангижруулах бодлогуудад нийтлэг ажиглагдаж байгаа хамгийн том давуу тал нь хүмүүсийг ямар нэгэн байдлаар хөдөлмөр эрхлүүлж, орлогын тогтвортой эх үүсвэртэй болгоход чиглэгдэж байгаа явдал юм.
8. Ядуурлаас ангижруулах бодлогуудтай хамт хэрэгжиж байгаа нэг том ажил нь хөдөө нутгийг автозам, харилцаа холбоо, цахилгаан, эмнэлэг, сургуультай болгож байгаа нь ядуу биш иргэдэд ч томоохон эерэг нөлөө үзүүлж байгааг цохон тэмдэг хэрэгтэй.

Хэдийгээр БНХАУ-ын төрөөс хэрэгжүүлж буй ядуурлаас ангижруулах бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаанд энэ мэт олон онцлох давуу талууд байгаа ч зарим анхаарах зүйлс ажиглагдаж байна. Тухайлбал,

1. Ядуурлаас ангижруулах бодлого нь асар хурдтай хийгдэж байгаа тул энэхүү огцом өөрчлөлтийн нийгэмд үзүүлэх нөлөөг судлах, болзошгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх ажлуудыг хийх хэрэгтэй (Ийм төрлийн ажил маш ховор хийгдэж байна). Жишээлбэл, цөөн тоот үндэстнүүдийн олон мянган жил уламжилж ирсэн зан заншил, амьдралын хэв маяг, соёлыг маш богино хугацаанд (5 жилийн дотор) өөрчлөх, магадгүй устгах аюул тулгарч болох юм. Түүнчлэн өндөр настнуудыг нүүлгэн шилжүүлж шинэ нутагт, шинэ орчинд аваачих нь дасан зохицоход төвөгтэй байдлыг үүсгэж байгааг анхаарч судлах шаардлагатай байна.
2. Энэхүү хээрийн шинжилгээний ажлаас харахад ихэвчлэн ахицааг насны иргэдийг орон сууцаар хангаж байгаа байдал түгээмэл байна. Үүний зэрэгцээ БНХАУ-ын төрөлтийн түвшин бага байгааг тооцон үзвэл суурин газруудыг шинээр байгуулж байгаа энэ үйл явц нь ирээдүйд хэр үр ашигтай болохыг тооцож үзэх хэрэгтэй мэт санагдана. Жишээлбэл, 20-30 жилийн дараа Өвөрмонгол эсвэл Гүйжөүгийн хаа нэгтээ эзгүй суурин, эзэнгүй байшин олон тоогоор үүсэх магадлал байгаа эсэхийг судлах шаардлагатай гэж үзэж байна.

3. Энэхүү өгүүллийг бичихдээ хээрийн шинжилгээний ажлын хүрээнд 10 гаруй жишээтэй танилцаж, хоёдогч мэдээллийн эх сурваж болох статистик тоо мэдээлэл, ядууралтай холбогдох бусад суурь судалгаануудыг ашиглан ядуурлаас ангижруулах бодлогын үр дүнгийн талаар тоймлон харуулсан боловч цаашид нарийвчилсан судалгаа хийх хэрэгтэй гэж үзэж байна.

Ашигласан материал

- Goh, Chor-ching; Xubei Luo; Nong Zhu (September 2009). "Income growth, inequality and poverty reduction: A case study of eight provinces in China". *China Economic Review*. 20 (3): 485–496.
- Jian, Tianlun; Jeffrey D. Sachs; Andrew M. Warner (1996). "Trends in regional inequality in China". *China Economic Review*. 7 (1): 1–21
- Liu Cui (2011) "The impact of china's gansu and inner mongolia poverty reduction project on net rural income per capita growth". Master thesis, University of California, San Diego
- Nogendra Sapkota, Sangui Wang, and Guobao Wu (2017) "Poverty reduction and development national strategies and a case study of adb-funded pilot project in Nayong county in Guizhou province, people's republic of china". ADB East Asia Working Paper Series
- Wang, S. (2001) "China's poverty statistics". *China Economic Review* 12 (2001) 384–398
- Weiss John, (2003) "Explaining Trends in Regional Poverty in People's Republic of China". ADB Institute Discussion Paper No1.
- Wu, J. P. (2005). China's Income Distribution, 1985-2001. *The Review of Economics and Statistics*, 87, 763-775.
- Yang, Dennis Tao (1999-05-01). "Urban-Biased Policies and Rising Income Inequality in China". *The American Economic Review*. 89 (2): 306–310.
- Yuan Zhang (2016) "Urbanization, Inequality, and Poverty in the People's Republic of China". ADBI Working Paper Series
- Zhong, Hai (March 2011). "The impact of population aging on income inequality in developing countries: Evidence from rural China". *China Economic Review*. 22 (1): 98–107. <https://web.archive.org/web/20110716071749/http://hdrstats.undp.org/en/indicators/103.html>
- [*"Overview"*](#). *Worldbank.org*. Retrieved December 28, 2017.
- [*"Latest data reveal how far away China is from the 2020 poverty elimination goal"*](#). *news.cgtn.com*. Retrieved June 1, 2019.
- <http://isdpeu/publication/chinas-anti-poverty-efforts-problems-and-progress/>
- <https://geopoliticalfutures.com/china-is-still-really-poor/>